

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ

№ 16/5

Улаанбаатар хот

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) нь 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хуралдсан бөгөөд хурлыг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдав.

МБЗ-ийн хурлаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулсан макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, гадаад эдийн засгийн орчин, мөнгөний бодлогын хүүг хэвээр хадгалах болон бууруулах хувилбар, тэдгээрийн үр нөлөө, нефтийн үнэ, төсвийн алдагдал зэрэг хүчин зүйлүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөг авч хэлэлцэв.

Хятад улсын эдийн засгийн өсөлт удааширсан хэвээр байгаа ч ОХУ болон Евро бүсийн эдийн засгийн өсөлт төсөөллөөс сайжрах хандлагатай байна. Манай улсын уул уурхайн экспортын гол түүхий эд болох зэс, алт, нүүрсний үнэ 2016 оны турш өсч байсан нь худалдааны нөхцөлийг сайжрууллаа.

Монгол улсын эдийн засаг 2016 оны 3 дугаар улиралд уул уурхай, барилга, худалдааны салбарын уналтын нөлөөгөөр 6.2 хувиар агшлаа. Харин бүтээгдэхүүний цэвэр татвар болон тээврийн салбар эдийн засагт эерэг нөлөө үзүүлсэн. Эрэлт талаасаа хөрөнгө оруулалт, засгийн газрын хэрэглээ өсөлтийг нэмэгдүүлсэн бол өрхийн хэрэглээ нь өсөлтийг бууруулах чиглэлд голлон нөлөөлсөн. Суурь төсөөллөөр эдийн засгийн өсөлт 2016 оны сүүлийн хагаст сөрөг болж, Оюу Толгой ХХК-ийн далд уурхайн хөрөнгө оруулалтын нөлөөгөөр 2017 оны сүүлийн хагаст эерэг болох хандлагатай байна. Эдийн засгийн идэвхжил саарснаас төсвийн орлого буурч, нөгөө талаасаа төсвийн зардал огцом нэмэгдсэнээр төсвийн алдагдал 2016 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 18.0 хувь, 2017 онд 9.1 хувьд хүрэхээр байна.

Жилийн инфляци суурь төсөөллөөр 2017 оны турш нам түвшинд хадгалагдах хэдий ч нийлүүлэлтийн шалтгаантай хүчин зүйлс болон гадаад, дотоод орчны гэнэтийн аливаа шок нь инфляцийн төсөөллийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж болно.

МБГ-ын зүгээс эдийн засгийн дотоод болон гадаад нөхцөл, төсвийн болон мөнгөний бодлогын төлөвийн талаар хэд хэдэн бодлогын арга хэмжээг танилцуулж, мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх саналыг дэвшүүлэв.

МБЗ-ийн хурлаар гишүүд Мөнгөний бодлогын газрын саналыг шүүмжлэх, дэмжих хэлбэрээр хэлэлцүүлэг өрнөлөө.

Мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх саналыг шүүмжилж байсан гишүүд манай улсын макро эдийн засгийн нөхцөл байдал тогтворгүй, дархлаа сул хэвээр байгааг анхааруулсан. Мөн эдийн засгийн суурь нөхцөлийг сайжруулах, өрийн дарамтыг шийдвэрлэх, санхүүжилт босгох ажил удааширч байгаа, төсвийн алдагдал, эдийн засгийн тодорхой бус байдлаас валютын ханшид нөлөөлөх эрсдэл байгааг онцолсон. Гишүүдийн зүгээс бодлогын хүүг бууруулах шийдвэрийн зах зээлд өгөх дохионы талаар болгоомжлохын зэрэгцээ Төв банкинд итгэх итгэл, 2016 оны 8 дугаар сарын бодлогын шийдвэрийг харгалзан бодлогын хүүг бууруулах цаг нь болоогүй гэж үзсэн.

Харин мөнгөний бодлогын саналыг дэмжиж байсан гишүүд 2016 оны 8 дугаар сард бодлогын хүүг 4.5 нэгж хувиар нэмэгдүүлсэн арга хэмжээ нь зорилгодоо хүрч, үр дүнгээ өгсөн гэж үзсэн. Үндэсний мөнгөн тэмдэгтийн болзошгүй хямралаас сэргийлэх зорилготой байсан энэхүү арга хэмжээний үр дүнд банкуудын төгрөг болон гадаад валютын хадгаламжийн хүүний зөрүү 11 дүгээр сарын байдлаар 3 орчим нэгж хувиар өссөн нь төгрөгийн активын харьцангуй өгөөж нэмэгдүүлсэн. Мөн эдийн засаг огцом агшиж байгаа үед Бодлогын хүүг өндөр хэвээр хадгалах нь бодит эдийн засагт улам сөргөөр нөлөөлнө гэдгийг дурьдсан. Суурь төсөөллөөр инфляцийн түвшин 2017 онд Төв банкны зорилтот түвшнээс доогуур байхаар хүлээгдэж байгаа нь мөнгөний бодлогын төлөвийг алгуур зөөлрүүлэх боломж үүсч байна гэсэн байр суурийг илэрхийлэв. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид хүлээлт илүү нөлөөлж байгаа үед төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх замаар ханшид нөлөөлөх боломж хомс юм. Зээлийн өсөлт сөрөг түвшинд удаан явсан, шинээр олгосон зээлийн үлдэгдэл багасч, банкууд хамгийн эрсдэл багатай зээлийг голлон олгох болсон нь бодит эдийн засагт зээлийн тасалдлын шинж тэмдэг илэрч буйг харуулж байна. Үүний зэрэгцээ эдийн засагт ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр хадгалагдах нь хистерис (hysteresis) үүсэх эрсдэл дагуулж байгааг зарим гишүүд анхааруулсан. Түүнчлэн УИХ, Засгийн газрын зүгээс мега төсөл, гадаад өрийн асуудлыг шийдвэрлэж, төлбөрийн тэнцлийг сайжруулах замаар ханшийн дарамтыг бууруулах нь чухал болохыг онцолсон. Мөн төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн тогтвортой байдал дунд хугацаанд тогтворжих боломж бүрдэж байгааг дурдсан.

Эдийн засгийн өсөлт саарч, том дүнтэй гадаад өрөө төлөх хугацаа ойртож байгаа үед макро эдийн засгийн эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авах шаардлагатай гэдгийг гишүүд онцолсон.

Ийнхүү МБЗ-ийн гишүүд мөнгөний бодлогыг зөөлрүүлэх саналыг тал бүрээс нь авч үзэн хэлэлцсэний эцэст Мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх, Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах томъёоллоор санал хураахад МБЗ-ийн гишүүдийн олонхи нь уг саналыг дэмжив.

Хэдийгээр макро эдийн засгийн тодорхой бус байдал, зах зээлийн эрсдэл үргэлжилсээр байгаа боловч эдгээрийг мөнгөний бодлогын өндөр хүүгээр засах зорилгоор цаашид мөнгөний бодлогын хүүг өндөр түвшинд удаан хадгалах нь бодит эдийн засгийн уналтыг илүү гүнзгийрүүлэх эрсдэлтэй байгаа тул мөнгөний бодлогыг зөөлрүүлэх, Төв банкны зүгээс бодит эдийн засгийг дэмжих нь зүйтэй гэж үзлээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны МБЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар Бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж, 14.0 хувь болгох шийдвэр гаргасан. Мөнгөний бодлогын шийдвэрийг 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтов.